



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/БЗ

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 44 дүгээр тушаалын 4.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор "Олон улсын нисэх онгоцны шинэ буудалд тавилга, эд хогшил" нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: Б.Хоролбат Худалдан авах ажиллагааны хэлтсийн менежер

Нарийн бичгийн

дарга: П.Хатанбаатар Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Г.Энхчулуун Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны захиргаа, хүний нөөцийн менежер

Б.Энх-Амгалан Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

С.Чинзориг Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Б.Хоролбат/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /П.Хатанбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН